



# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Авто замын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжийн  
хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн бодлого,  
хэрэгжилт, үр дүн*



**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ЗОХИСТОЙ БҮТЭЦ БИЙ БОЛООГҮЙ БАЙНА**

<b>Агуулга</b>	<b>Товчилсон үгс</b>	2
	<b>Аудитын зорилт, арга зүй, хамарсан хүрээ</b>	3
<b>Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</b>	<b>Бүлэг 1. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бодлого, хууль, журмыг мөрдөөгүй байна</b>	4
<i>Газрын захирал:</i> Д.Ганбилэг	<i>Гэрээ батлагдсанаас хойш 2 жилийн дараа хэрэгжиж эхэлжээ</i>	4-6
<i>Аудитын менежер:</i> Х.Баярмаа	<i>Худалдан авах ажиллагаанд хоёр жил зарцуулжээ</i>	7
<i>Ахлах шинжээч:</i> У.Баярмаа	<i>Төсөл хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах оновчтой бүтэц бий болоогүй байна</i>	8
<i>Шинжээч:</i> Ц.Эрдэнэчулуун	<i>Төсөл хэрэгжүүлэгч байгууллага журмын заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна</i>	8-9
Ж.Оюунтуяа М.Доржмаа Л.Батжаргал	<i>Төслийн удирдах хороо 2011 оноос хойш үйл ажиллагаа эрхлээгүй байна</i>	9
	<i>Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төлөвлөгөөт ажил хэрэгжихгүй байна</i>	10-12
	<b>Бүлэг 2. Төсөл хөтөлбөрийн явц удаашралтай байна</b>	13-14
<b>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</b>	<i>Зам барилгын ажил гүйцэтгэх гэрээ удаа дараа цуцлагджээ</i>	14
www.mnao.mn	<i>Засгийн газрын тогтоолоор батлагдсан гадаадаас авах ажиллах хүчний 37.2-69.6 хувь орж ирсэн байна</i>	14-15
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261456 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<i>Зам барилгын ажилд стандарт, норм дүрмийг мөрдөж ажиллахгүй байна</i>	17
	<i>Зөвлөх компанийн ажил хангалтгүй нь замын чанар муудахад нөлөөлсөн байна</i>	18
<b>ХАЯГ:</b>	<b>Дүгнэлт</b>	20
<i>Үндэсний аудитын газар</i>	<b>Зөвлөмж</b>	21
<i>Чингэлтэй дүүрэг,</i>	<b>Холбогдох байгууллагын санал</b>	22
<i>Бага тойруу-3,</i>	<b>Саналд өгөх тайлбар</b>	23
<i>Засгийн газрын IV байр</i>	<b>Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал</b>	24
<i>Улаанбаатар хот 15160</i>		
<i>Монгол Улс</i>		

## ТОВЧИЛСОН ҮГС

<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>МУЗГ</b>	Монгол Улсын Засгийн газар
<b>ТБОНӨХБАҮХА</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
<b>ЗТБХБС</b>	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
<b>ЗТАЖС</b>	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд
<b>НХХЯ</b>	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
<b>ГЗТХБ</b>	Гадаадын зээл тусламж хариуцсан байгууллага
<b>ГИХАЭГ</b>	Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх газар
<b>ХХҮГ</b>	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
<b>ТХБ</b>	Төсөл хэрэгжүүлэх байгууллага
<b>АЗГ</b>	Авто замын газар
<b>ТУХ</b>	Төслийн удирдах хороо
<b>ТХН</b>	Төсөл хэрэгжүүлэх нэгж
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>ХБНГУ</b>	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
<b>ШУТИС</b>	Шинжлэх ухаан технологийн их сургууль
<b>МСҮТ</b>	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
<b>ТАХ</b>	Төсөл, арга хэмжээ

## Аудитын зорилт, арга зүй, хамарсан хүрээ

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийлээ.

### Аудитын зорилт, хамарсан хүрээ

Авто замын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн бодлого, хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүнг холбогдох байгууллага, олон нийтэд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Авто замын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр төрийн бодлого хууль журамтай уялдаж байгаа эсэх
- Авто замын салбарт гадаадын зээл тусламжаар, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитад Сангийн яамны Гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газар, ЗТБХБЯ, Авто замын газар, Төслийн удирдах хороо, Төсөл хэрэгжүүлэх нэгж, зөвлөх, гүйцэтгэгч компаниуд хамрагдлаа. Авто замын салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа нийт 12 төсөл хөтөлбөрөөс 6 төслийг сонгон авч тэдгээрийн хэрэгжилтийн явцад аудит хийв.

### Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж асуулга, лавлагаа, тайлбар мэдээ гаргуулах, ажлын явц, хэрэгжилтийг захиалагч, зөвлөх компани болон гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөллийг байлцуулан газар дээр нь танилцан бичгээр тайлбар авч холбогдох нотлох баримтыг гаргуулах, фото зургаар баталгаажуулах, санхүүгийн, үйл ажиллагааны, хяналтын хэсгийн тайланг судалж шалгуур үзүүлэлт, бодит байдалтай харьцуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитыг хянан баталгаажуулах журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бодлого, хууль, журмыг мөрдөөгүй байна**

**Гэрээ батлагдсанаас хойш хоёр жилийн дараа хэрэгжиж эхэлжээ**

1.1 2011 оны байдлаар авто замын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн 70.0 хувийг хөнгөлөлттэй зээлээр, 30.0 хувийг буцалтгүй тусламжаар буюу нийт 1006.4км хатуу хучилттай авто зам, 262 у/м гүүрэн гарцыг барьж байна. Төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэгч байгууллагаар авч үзвэл:

Төсөл хөтөлбөр	Зээлийн хөрөнгө /км /	Буцалтгүй тусламжийн хөрөнгө /км /
Азийн хөгжлийн банк	131.2	61.8
	62	110.8
	18.2	
	15.5	
	103.3	
	15.3	
	<b>345.8</b>	<b>172.6</b>
АНУ-ын Мянганы сорилтын сан	-	<b>176.4</b>
БНХАУ –ын Засгийн газар	85.3	
	60.0	-
	<b>145.3</b>	
Германы сэргээн босголт банк	17.0	
	29.3	
	32.2	-
	<b>78.5</b>	
Японы улсын засгийн газар	-	262 у/м+633 м
Кувейтын сан	<b>88</b>	-
<b>Дүн</b>	<b>657.4</b>	<b>349.0</b>

1.2 Хэрэгжиж байгаа болон төлөвлөгдсөн төсөл, хөтөлбөрийн талаарх нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, зээл тусламжийн хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлж, хөрөнгийг үр дүнтэй ашиглан хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналтыг сайжруулах ажлыг дараах хууль журмаар зохицуулж байна.

Хууль, журмын нэр	Батлагдсан	
	Дугаар	Нэр, огноо
Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль	УИХ	2003.06.12
Гадаадын зээл, тусламжийн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, ашиглах журам	Сангийн сайдын 447дугаар тушаал	Журам батлах тухай 2006.12.27
Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам	Сангийн сайдын 120 дугаар тушаал	Журам батлах тухай 2007.05.07
Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам	Сангийн сайдын 86дугаар тушаал	Журам шинэчлэн батлах тухай 2011.04.14
Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийн төлбөр тооцоог төрийн сангаар дамжуулан гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулах журам	Сангийн сайдын 123дугаар тушаал	Журам батлах тухай 2011.06.2

1.3 1996 оноос авто замын салбарт гадаадын санхүүжүүлэгч байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар хэд хэдэн томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж аймаг хотуудыг холбосон авто зам барьж, шинэчлэн

ашиглалтад оруулснаар манай улсын хатуу хучилттай замын сүлжээний урт 50-60 хувиар өсчээ.

1.4 2005-2012 онд авто замын салбарт зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй дараах төсөл, хөтөлбөрийн санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ-аар соёрхон баталсан байна. Үүнд:

№	Төслүүдийн нэр	км-ээр	УИХ-аар соёрхон баталсан огноо	Тендер сонгон шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан огноо
1	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл		2005.07.1	2006.12.28
2	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх	Багц 1-110.8	2010.4.30	2010.12.22
		Багц 2- 85.3	2008.4.18	2010.08.04
		Багц 3- 60.0		
		Багц4-103.3		
3	УБ хотын хүнсний хангамжийг сайжруулах бүс нутгийн тээврийн дэд бүцийг хөгжүүлэх төсөл	Багц 1- 32.2	2010.12.9	2012.02.01
		Багц 2- 17.0	2011.1.27	2012.1.31
		Багц 3 -29.3	2012.5.18	тендер шалгаруулалтын шатанд
4	Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор авто зам барих		2008.9.01	2010.7.09
				2011.8.15
				2011.8.15
				2011.12.9
				2011.12.9
5	Уньт–Тариалан чиглэлийн авто замын төсөл		2010.5.05	2012.4.23
6	Төмөр зам дээгүүр гүүрэн гарц барих		2009.12.31	2009.10.5

1.5 Зарим төсөл хөтөлбөрүүдийн хувьд зээлийн гэрээ УИХ-аар соёрхон батлагдсанаас хойш санхүүжүүлэгч байгууллагатай тендерийн багцлал, гэрээний хугацаа, тендерийн баримт бичиг, хөрөнгө оруулалтын хуваарь гэх мэт асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэхэд 2 жил зарцуулж байгаагаас төсөл богино хугацаанд хэрэгжиж чадахгүй байна.

1.6 Аудитад хамрагдсан 6 төсөл хөтөлбөрөөс гадна “Улаанбаатар хотын авто замыг сайжруулах” төслийн хүрээнд 2008-2013 онд нийслэлд 19.3 км авто зам баригджээ. Мөн Япон Улсын Засгийн Газрын зээлээр олон улсын нисэх онгоцны буудал барихтай холбогдуулан нийслэлийг шинэ нисэх буудалтай холбох хурдны замыг Монгол Улсын Засгийн газрын нэмэлт хөрөнгөөр санхүүжүүлэн барихаар төлөвлөсөн байна. Тухайлбал:

№	Төслийн нэр	Хэрэгжих хугацаа	Санхүүжүүлэгч	Хэрэгжүүлэгч
1	Ботаник-Шархад чиглэлийн 6.5 км замын зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээний ажил	2008-2012	АХБ	ЗТБХБЯ
2	Тахилтын 7.1 км зам барих			
3	Хайлаастын 1.1 км зам барих			
4	Баруун салааны 4.6 км зам барих			
5	Замын лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах			
6	Хөшигийн хөндийд олон улсын нисэх онгоцны буудал барихтай холбогдуулан хурдны зам барих	2010 -2013	Концессийн гэрээгээр	

1.7 Монгол Улсын Засгийн газар олон улсын санхүүжүүлэгч байгууллагаас авах зээл тусламжийн гэрээг байгуулахдаа зарим тусгай шаардлагын нөхцлийг Монгол Улсад хэрэгжих боломжтой эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй байна. *Тухайлбал:*

*Арабын эдийн засгийн Кувейтын сангийн зээлээр хэрэгжиж буй Булган аймгийн Уньт-Тариалан чиглэлийн авто замын төслийг хэрэгжүүлэх зээлийн гэрээний хавсралтад: Зөвлөх үйлчилгээний хувьд тендер нь Кувейт болон Монголын зөвлөхүүдийн хамтарсан компаниудаар хязгаарлагдана.*

*Тендерийн урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтийг зөвхөн Кувейт Монголын хамтарсан компаниудаас авна.*

*Мөн гэрээнд заасан тендерт оролцогчид өгөх зааварчилгаанд: 5.3 в-д Сүүлийн 3 жилийн дотор 14 сая ам.долларын өртөг бүхий ажлыг тухайн төсөл хэрэгжих газартай байгаль орчны хувьд ижил төстэй нөхцөлд гүйцэтгэсэн байх.*

*5.4 е-д Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн /5 сая ам.доллар/ байна гэж заасан нь үндэсний компаниудын хувьд тендерт оролцох боломжийг хязгаарласан байна.*

1.8 Зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа авто замын төслүүдийн гүйцэтгэгчээр ихэвчлэн гадны компаниуд шалгаран ажиллаж байгаа нь үндэсний компаниудын өргөжин тэлэх, ажил гүйцэтгэх дадлага туршлагыг олж авах, чадавхи нэмэгдэх боломжийг бууруулж байна.

*Тухайлбал:*

*Авто замын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний компаниуд нь ихэвчлэн 50-10 км замын гүйцэтгэгчээр ажиллаж байна. Тус компаниуд 100 км зам барихад 400 км замд ажиллах мэргэжилтэй ажилчдын тоо шаардлагагүй бөгөөд энэ хэмжээгээр бэлтгэгдсэн болон бэлтгэгдэж байгаа ажиллах хүчийг шингээх чадвар муутай байна.*

1.9 Сүүлийн жилүүдэд авто замын салбарын хөрөнгө оруулалт өссөнтэй холбогдон ажлын байр нэмэгдэж байгаа ч мэргэжлийн ажиллах хүчний тоо хангалтгүй байна. 2010 оны байдлаар тус салбар инженер техникийн ажилтан 478, мэргэжилтэй ажилчин 590, механизмчин 300, нийт 1300-1400 хүний ажиллах хүчний нөөцтэй байна. /эх сурвалж АЗГ-с/

2011, 2012 онд замын салбарт нэмж шаардагдах ажилтнуудын тоо



1.10 Дээрх зургаас харахад 2011-2012 онд авто замын салбарт инженер техникийн ажилтан 350, механизмчин 670, мэргэжилтэй 2010, туслах 4020 ажилчид, нийт 7050 хүн нэмж шаардагдаж байна.

1.11 Инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид, механизмчдийн тоо төдийлөн өсөхгүй байгаа нь бэлтгэн гаргадаг сургууль, төгсөгчдийн тоо цөөн байгаатай холбоотой байна.

1.12 Манай улсад авто замын инженер техникийн ажилтанг ШУТИС, Техник технологийн коллежид, мэргэжлийн замчин, механизмчдыг Авто замчдын холбооны дэргэдэх сургалтын төвд тус тус бэлтгэж байна.

1.13 2010 онд үйлдвэр дээр мэргэжлийн сургалт хийх эрхийг зам барилгын 10 аж ахуйн нэгж авч, 2 ээлжээр сургалт явуулан, нийт 550 хүнийг практик сургалтын чиглэлээр бэлтгэж байна.

1.14 Гэсэн ч мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр мэргэжлийн боловсон хүчин хангалттай бэлтгэгдэхгүй байна.

1.15 Мэргэжилтэй ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, инженер техникийн ажилтанг давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох сургалтуудыг зохион байгуулах ажил хангалтгүй байна.

1.16 Мөн түүнчлэн хөдөлмөр хамгаалал, ажлын болон түр амьдрах байрны нөхцөл хангалтгүй байдаг нь зам барилгын үйлдвэрлэл дээр ажиллах хүмүүсийн сонирхлыг бууруулж байна.

### ***Худалдан авах ажиллагаанд хоёр жил зарцуулжээ***

1.17 Сангийн сайдын 2007 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан ТБОНӨХБАУХА ажиллагааг тайлагнах журмын 2.6<sup>1</sup>, 2.9<sup>2</sup> дэх заалтын дагуу үнэлгээний хороо байгуулагдаад сонин хэвлэлд тендерийн урилга нийтлүүлэхэд 21, тендер зарлаад гэрээ байгуулах эрх олгосон тухай оролцогчид мэдэгдэхэд 90 хоног зарцуулахаар байна. Гэтэл ЗТБХБЯ-ны 2009-2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангаас түүний хэрэгжилтийг тооцож үзэхэд дараах байдалтай байна.

№	Төслийн нэр	Чиглэл, багцын нэр	Үнэлгээний хороо байгуулагдсанаас урилга нийтлүүлсэн хүртэлх хугацаа	Тендер зарласнаас хойш гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгосон хугацаа
1	Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл	Сайншанд-Замын Үүд чиглэлийн зам	152	98
		Сайншанд-Замын Үүдийн 61.8 км зам	35	254
		"Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-н хүрээнд мод тарих ажил	100	Багц NP2-д шилжсэн

2.6<sup>1</sup>-Захиалагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл бүрээр Маягт 4-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны явцад хэрэгжүүлэх арга хэмжээ, үе шатыг тодорхойлон тусгасан байна.

2.9<sup>2</sup>- Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх асуудлын хүрээний төсвийн багцаас санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд маягт 4-ийн дагуу тухай бүр хяналт тавьж, дүгнэлт гаргаж, шаардлагатай тохиолдолд худалдан авах ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн холбогдох арга хэмжээг авна.



		"Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-н мод тарих ажил /Дорноговь/	747	44
2	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл	Багц 3- 85.3 км, багц 5- 60 км авто зам	372	28
		Багц 2 Бага улаан даваа - Манхан чиглэлийн 103.3	195	44
3		Зөвлөх сонгон шалгаруулах	211	216
4	УБ хотын хүнсний хангамжийг сайжруулах төсөл	Партизан чиглэлийн 17км авто зам	150	422
		Жаргалант, Борнуурын 32.2км зам	158	78
		29.3 кмзам /Борнуур, Жаргалант/	139	Үнэлгээнд
5	Уньт-Тариалангийн авто зам барих төсөл	Уньт-Тариалан чиглэлийн 88 км зам	416	172
6	"Хот байгуулалтын салбар"-ын төсөл	Хайлааст, БаруунСалаа, Орбит-Тахилт замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах	137	244
		Замын лабораторийн тоног төхөөрөмж хангах нийлүүлэх	340	95
7	Мянганы сорилтын сангийн авто замын төслийн хүрээнд баригдах Баянзүрхийн товчооноос Налайх-Чойрын уулзвар хүртэлх 17.5 км замын инженерийн нарийвчилсан хайгуул, зураг төсөл боловсруулах ажил		14	63

1.18 Үнэлгээний хороо байгуулагдаад тендерийн урилга сонинд нийтлэхэд 14-726, гэрээ байгуулах эрх олгоход 5-332 хоногоор ажил удааширсан нь тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах явцыг захиалагч байгууллага шуурхай зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүйг харуулж байна. *Тухайлбал:*

- УБ хотын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төслийн 1-р багцын 17 км замын тендерийн үнэлгээний хороо байгуулагдсанаас урилга нийтлүүлсэн хүртэл хугацаа 150 хоног;
- Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор баруун бүсийн туслах зам барих төслийн тендер зарласнаас хойш гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгоход 216 хоног тус тус зарцуулсан байна.

**Төсөл хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах зохистой бүтэц бий болоогүй байна**

1.19 Гадаадын зээл тусламжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь 2003 оны "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль" болон Сангийн сайдын 2007 оны 120 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ын дагуу ТХН-ийн орон тоо, үйл ажиллагааны зардлыг баталж, ТХБ-ын саналыг үндэслэн зээл тусламжийн хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, төслийн гадаад дотоод эх үүсвэрээс бүрдэх хөрөнгийн хэмжээг дараа оны төсөвт тусгах, зарцуулалтад зээлдэгчтэй хамтран хяналт тавих үүрэгтэй байна.

1.20 Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар дээрх журам<sup>3</sup> шинэчлэгдсэнтэй холбогдуулж 2011 оны 9 дүгээр сараас төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, нэгдсэн зохицуулалтаар хангах зорилгоор авто замын салбарт 2013 он

<sup>3</sup>"Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"

хүртэл бүтцийн өөрчлөлтийг туршилтаар хэрэгжүүлэхээр “Бүтцийн өөрчлөлт хийх туршилт хэрэгжүүлэх тухай” Сангийн сайд, ЗТБХБС-ын 2011 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 237/187 дугаар тушаалыг мөрдөн ажиллаж байна.

1.21 “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 3.11<sup>4</sup>-т “төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийн эрх үүргийг тодорхойлсон боловч Сангийн сайд, ЗТБХБС-ын 2011 оны 237/187 дугаар тушаалын 4-т төсөл хэрэгжүүлэх нэгжийг татан буулгасан байна. Мөн АЗГ-ын орлогч даргыг үндсэн ажлын зэрэгцээ төслийн захирлаар томилон ажиллуулахаар заажээ.

1.22 Энэ нь нэг талаас бүтцийг сайжруулсан мэт харагдаж байгаа боловч ТХН-үүдийн бүтэц зохион байгуулалт ойлгомжгүй, шат дамжлага нэмэгдэх хандлагатай болжээ.

1.23 ГЗТХБ журмын 5.1.2<sup>5</sup> дугаар заалт, Сангийн сайд, ЗТБХБС-ын хамтарсан тушаалыг үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн ерөнхий нягтлан бодогчийг томилон ажиллуулсан боловч журмын 5.1.3-т нягтлан бодогчийн ур чадварыг шалгах зорилгоор туршилтын 6 сарын хугацаанд ажиллуулж”..... гэснийг зөрчиж туршилтын хугацааг 1 сар буюу 30 хоногийн хугацаанд дуусгавар болгосон байна.

### ***Төсөл хэрэгжүүлэгч байгууллага журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна***

1.24 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төслийн удирдах хороог байгуулж, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч, ажилтнуудыг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, төслийн ажлын явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах, эрх үүрэгтэй.

1.25 Төслийн зохицуулагч нь журмын 3.1.12<sup>6</sup>-т зааснаар төслийн захиралтай шууд харилцан ажиллаж, ажлын явцыг тайлагнах үүрэгтэй бөгөөд төслийн захирал нь ТУХ-нд төслийн хөрөнгийн зарцуулалт, ажлын явц, үр дүнгийн талаар тайлан мэдээ гаргаж өгөх үүрэгтэй байна.

1.26 Төсөл хэрэгжүүлэх байгууллага 2011 оноос хойш төслийн ажлын явцад дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргаагүй байна.

### ***Төслийн удирдах хороо 2011 оноос хойш үйл ажиллагаа эрхлээгүй байна***

1.27 Авто замын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнд шинжилгээ дүгнэлт хийж, шаардлагатай заавар зөвлөмжөөр хангах зорилгоор ЗТАЖС-ын 2004 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 20 дугаар тушаалаар анхны төслийн удирдах хороо байгуулагдсан байна. ТУХ-ны гишүүдийн бүрэлдэхүүнд зарим яам, холбогдох газруудын төлөөллийг оролцуулах зорилгоор 2007 онд 20 дугаар тушаалыг шинэчилж ТУХ-ны даргаар ЗТБХБ-ын дэд сайдыг томилон ажиллуулжээ.

1.28 2009 оны 3 дугаар сарын 23-ны өдөр дээрх тушаалыг дахин шинэчлэн баталснаар, Азийн хөгжлийн банк, Кувейтын сан, БНСУ-ын ЗГ-ын хөнгөлттэй зээл,

<sup>4</sup>Зээл, тусламжийн хэлэлцээр болон түүнтэй холбогдох бусад баримт бичигт заасан ажлыг хугацаанд нь бүрэн чадварлаг хэрэгжүүлэх үүрэг бүхий төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах, төслийн зохицуулагч болон бусад ажилтнуудаас бүрдсэн орон тооны нэгжийг хэлнэ.

<sup>5</sup>Төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн нягтлан бодогчийг ТХБ-ын сонгон шалгаруулалтын материал, хурлын дүгнэлтийг үндэслэн ГЗТХБ-ын төсвийн ерөнхий менежерийн тушаалаар ажиллуулахаар томилох

<sup>6</sup>... зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтыг гүйцэтгэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтыг хөтлөх, төслийн явцыг төслийн захиралд шууд тайлагнаж, түүгээр холбогдох шийдвэрийг гаргуулах үүрэг бүхий ...

ХБНГУ-ын Сэргээн босголт банкны хөнгөлттэй зээл, Япон улсын ЗГ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн нэгдсэн удирдах хороо байгуулагджээ.

1.29 Тус хороо 2011 оны 6 дугаар сараас хойш үйл ажиллагаа эрхлээгүй бөгөөд “Бүтцийн өөрчлөлт хийх туршилт хэрэгжүүлэх тухай” Сангийн сайд, ЗТБХБС-ын 2011 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 237/187 дугаар тушаалаар төслүүдийн удирдах хороог нэгтгэн даргаар ЗТБХБЯ-ны төрийн нарийн бичгийн даргыг томилсон байна.

1.30 Гэтэл ТУХ-ны дарга томилогдсоноос хойш тус хорооны үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа нь тодорхойгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмын 7.2.1<sup>7</sup>, 7.2.2<sup>8</sup>, 7.3.3<sup>9</sup>-т заасныг тус тус зөрчжээ.

1.31 Төслүүдийн 34 хувь ТУХ-той боловч огт хуралдаагүй буюу журамд заасан хугацаандаа хуралдаагүй байгаа нь төслийн хэрэгжилтийг хэлэлцэх, ажлын явцад гарч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, төслийн захирал, хэрэгжүүлэх нэгжид заавар, зөвлөмж өгөх, удирдамжаар хангах үүрэг хэрэгжихгүй байгааг харуулж байна.

№	Төслүүдийн нэр	ТУХ байгуулсан огноо	ТУХ-ны хуралдаан		Хуралдаанаас гаргасан шийдвэр
			Журмын дагуу /7.2.1/	хуралдсан	
1	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл	2009.3.23	4	2	Гэрээ сунгах, сунгасан хугацаанд ажил дуусаагүй бол торгууль ногдуулах, ажил шуурхайлах, гадаадаас ажиллах хүч оруулахтай холбогдсон материалыг хугацаанд нь НХХЯ-д хүргүүлэх
2	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх	2009.3.23	4	0	хуралдаагүй
3	Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор авто зам барих	-	4	0	хуралдаагүй
4	Уньт–Тариалан чиглэлийн авто замын төсөл	2009.3.23	4	0	хуралдаагүй
5	УБ хотын хүнсний хангамжийг сайжруулах тээврийг хөгжүүлэх	-	4	0	хуралдаагүй
6	Төмөр зам дээгүүр гүүрэн гарц барих	-	4	0	хуралдаагүй

7.2.1<sup>7</sup>-“зээл тусламжийн хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол төсөл удирдах хороо нь улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүрт хуралдах

7.2.2<sup>8</sup>-Зээл тусламжийн хэлэлцээр болон холбогдох бусад баримт бичигт тусгагдсан төслийн хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор төслийн захирал, төсөл хэрэгжүүлэх нэгжийг шаардлагатай удирдамжаар хангах


7.3.3<sup>9</sup>- Төсөл хэрэгжүүлэх талаар гарч буй аливаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх талаар заавар, зөвлөмжийг төслийн захирал болон төсөл хэрэгжүүлэх нэгжид тухай бүр өгөх

### Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төлөвлөгөөт ажил хэрэгжихгүй байна

1.32 Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төсөлтэй холбогдох асуудлыг ТХБ, ТУХ-нд тавьж шийдвэрлүүлэх, төслийн зорилтын биелэлт, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, төслийн хүрээнд нийлүүлэгдэх бараа, ажил үйлчилгээ, хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлт зэрэгт хяналт тавьж, тайланг ТУХ-нд танилцуулах, санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж өгөх үүргийг хүлээсэн байна.


1.33 Зээлийн олон улсын гэрээний нөхцөлд “Төслийг үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс зээлдэгч тал нь гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш нэг сарын дотор төслийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хангах төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулах бүх шаардлагатай арга хэмжээг авна” гэж заажээ.

1.34 Дээрх гэрээнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын 2007 оны 120 дугаар тушаалын дагуу дараах бүтцээр төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулдаг байжээ.



1.35 Энэ бүтцэд тусгаснаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг төслийн удирдагч ЗТБХБЯ болон санхүүжүүлэгч байгууллагатай шууд харилцаж шийдвэрлэсээр ирсэн байна.

1.36 “Бүтцийн өөрчлөлт хийх туршилт хэрэгжүүлэх тухай” Сангийн сайд, ЗТБХБС-ын 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 237/187 дугаар тушаал батлагдсанаар ТХН-ийн бүтцийг дараах зохион байгуулалтад оруулжээ.



1.37 Дээрх бүтцээр төслийн зохицуулагч, ЗТБХБЯ, санхүүжүүлэгч байгууллагын дунд төслийн санхүүгийн алба, төслийн захирал, АЗГ гэсэн дамжлагууд бий болж асуудал шийдвэрлэхэд цаг хугацаа алдсан байна.

1.38 Зөвхөн нэг төсөл арга хэмжээгээр жишээ авахад худалдан авах ажиллагаатай холбогдох бичиг, баримтыг боловсруулж холбогдох газраас зөвшөөрөл авч шийдвэрлэхэд дээрх бүтцийн дамжлагаар 650 хоног буюу 22 сарын хугацаа зарцуулсан байна. Тухайлбал: Уньт-Тариалан чиглэлийн 88 км авто замын гүйцэтгэгч шалгаруулах 4 удаагийн тендерт зарцуулсан хугацааг үзүүлвэл:

№	Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авсан арга хэмжээ	Зарцуулсан хугацаа
1	Боловсруулсан тендерийн баримт бичигт зөвшөөрөл авах	10
2	СЯ-ны шийдвэрийн дагуу тендерийн баримт бичгийг дахин боловсруулж, хүргүүлэх	65
3	Дахин боловсруулсан тендерийн баримт бичигт зөвшөөрөл авах	19
4	Санхүүжүүлэгч талын саналыг тендерийн баримт бичигт тусгаж, зөвшөөрлийг авах	40
5	Тендерийг зарлах	4
6	Тендерийг нээх	66
7	Эхний тендерийг хүчингүй болгож, дахин тендер зарлах зөвшөөрөл авах	19
8	Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг дүгнэж, асуудлыг шийдвэрлүүлэх	Хариу ирээгүй
9	Тендерийг зарлах	14
10	Тендерийг нээх	30
11	2 дахь тендерийг хүчингүй болгож, хязгаарлагдмал тендерийн зөвшөөрлийг СЯ-наас авах	12
12	Хязгаарлагдмал тендерийн зөвшөөрлийг Сангийн яаманд талд хүргүүлэх	9
13	Сангийн яамнаас талаас хязгаарлагдмал тендерийн зөвшөөрлийг авах	18
14	Тендер шалгаруулалтын явцыг дүгнэж, асуудлыг шийдвэрлүүлэх тухай бичиг	Хариу ирээгүй
15	Хязгаарлагдмал тендерийг зарлах	11
16	Тендерийн нээлт	14
17	Тендер шалгаруулалтын явцыг дүгнэж, асуудлыг шийдвэрлүүлэх тухай бичиг	6
18	Асуудлыг шийдвэрлүүлэх тухай бичгийг СЯ-аар шийдвэрлүүлэх	22
19	Тендерийг ОУ-ын нээлттэй хэлбэрээр явуулах зөвшөөрлийг санхүүжүүлэгч талаас авах	12
20	Тендерийг зарлах	9
21	Тендерийн нээлт	30
22	Техникийн саналын үнэлгээг хийх	23
23	Санхүүжүүлэгчээс санхүүгийн санал нээх зөвшөөрөл авах	140
24	Санхүүгийн саналын нээлт	6
25	Тендерийн хүчинтэй хугацааг сунгах	30
26	Санхүүгийн саналын үнэлгээг хийх	18
27	Санхүүгийн тайланд хариуг авах	23
<b>НИЙТ ХОНОГ</b>		<b>650</b>

1.39 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн жилийн төлөвлөгөөт ажлын 30-45 хувь дутуу буюу огт хэрэгжихгүй байна. Зээлийн гэрээнд зааснаар төслийг хуваарийн дагуу хэрэгжүүлж зам барилгын ажлын техникийн шаардлага болон хэрэгжилт ажлын графикийн дагуу явж байгаа эсэхэд хяналт тавих төлөвлөгөөт ажил ихэвчлэн хэрэгжээгүй байна.

№	Төслүүдийн нэр, код	Хамрах хүрээ	Төлөвлөсөн ажлын хэрэгжилт												
			2008			2009			2010			2011			2011 оны хэрэгжээгүй ажлын хувь
			төлөвлөсөн	хэрэгжсэн	Дутуу болон хэрэгжээгүй	төлөвлөсөн	хэрэгжсэн	Дутуу болон хэрэгжээгүй	төлөвлөсөн	хэрэгжсэн	Дутуу, хэрэгжээгүй	төлөвлөсөн	хэрэгжсэн	Дутуу, хэрэгжээгүй	
1	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл	ТХН-ийн үйл ажиллагааны	15	11	4	15	11	4	15	11	4	35	25	10	<b>28.6</b>
2	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх	ТХН-ийн үйл ажиллагааны	-	-	-	9	6	3	9	8	1	8	8	-	<b>33.0</b>
3	Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор авто зам барих	ТХН-ийн үйл ажиллагааны	-	-	-	2	2	-	4	4	-	8	8	-	<b>0</b>
4	Уньт–Тариалан чиглэлийн авто замын төсөл	ТХН-ийн үйл ажиллагааны	-	-	-	-	-	-	-	-	-	26	14	12	<b>46.1</b>
5	УБ хотын хүнсний хангамжийг сайжруулах тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл	ТХН-ийн үйл ажиллагааны	-	-	-	-	-	-	-	-	-	23	13	10	<b>43.4</b>
6	Төмөр зам дээгүүр гүүрэн гарц барих “Нарны гүүр төсөл”	ТХН-ийн үйл ажиллагааны	-	-	-	-	-	-	-	-	-	12	12	-	<b>0</b>

**Гадаадын зээл тусламжаар, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн явц удаашралтай байна**

**Зам барилгын ажил гүйцэтгэх гэрээ удаа дараа цуцлагджээ**

2.1 Зам барилгын ажлыг гүйцэтгэхээр тендерт шалгарсан гадаад, дотоодын гүйцэтгэгч компаниудын ажил графикын дагуу хэрэгжээгүйгээс хугацаа хоцорсны торгуульд орж, санхүүгийн хувьд хүндрэлтэй тулгарч, улмаар гэрээг цуцлахад хүрч байгаад дараах шалтгаанууд нөлөөлж байна.



*АХБ-ны хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдаж байгаа зам барилгын ажлууд хугацаандаа дуусч ашиглалтанд ороогүй байна.*

*Мянганы сорилын сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа Чойр-Сайншандын 176,4 км замын гүйцэтгэгчээр 2007-2009 онд БНСУ-ын Ханшин инженеринг, 2009-2010 онд LIG компаниуд ажиллаж байгаад гэрээг цуцалсан байна. Үүний улмаас 2011 онд зам барилгын ажил хийгдээгүй, дахин гүйцэтгэгч шалгаруулах тендер зарласнаар 2012 оны 4 дүгээр сараас дахин зам барилгын ажил эхэлжээ.*

2.2 1998-2004 онд хэрэгжиж байсан төслүүдийн хэрэгжилт 1-3 жилийн хугацаагаар хоцорч байсан бол 2005 оноос хойших төслүүдийн хэрэгжилт 4-5 жилээр хугацаа хэтэрч байна. *Тухайлбал: 1998-2004 онд хэрэгжиж байсан төслүүд:*

	Төслүүдийн нэр	км	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч	Зөвлөх	Хэтэрсэн хугацаа жилээр
1	УБ-Алтанбулаг	245	АХБ	Санван корпораци (БНСУ)	ICT	2
2	Дархан-Эрдэнэт	180	Кувейтийн сан	Чикен групп (БНХАУ)	ICT	3
3	Налайх-Чойр	200	АХБ-М	Чайна тысьчу групп (БНХАУ)	JOC	1
4	Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл	106	Дэлхийн банк	Монголын компаниуд	Скотт Вилсон Киркпатрик	0.5
5	Эрдэнэт-Булган-Уньт	146	Кувейтийн сан	CGC-Кувейт Монголын компаниуд	ICT	3
6	Бүс нутгийн тээврийг хөгжүүлэх төсөл	61	KFW	Монголын компаниуд	ICT	1

2.3 Энэ нь гүйцэтгэгч байгууллагын гэрээг хэрэгжүүлэх зохион байгуулалт хангалтгүй, хүлээх хариуцлага сул, хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд баригдаж байгаа зарим замууд хугацаандаа ашиглалтад ороогүйгээс манай

улсын авто замын сүлжээ төдийлөн нэмэгдэхгүй, хүн амд ногдох замжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Место	Страна	Результат 2011 (2009)
1	Сингапур	6,6 (6,6)
2	Франция	6,6 (6,7)
3...	Швейцария	6,5 (6,7)
...122	Буркина Фасо	2,6 (2,7)
123	Сербия	2,5 (2,4)
124	Казахстан	2,4 (2,5)
125	Россия	2,4 (2,5)
126	Чад	2,4 (1,6)
127	Мауритания	2,4 (2,1)
128...	Нигерия	2,4 (2,3)
...137	Босния и Герцоговина	1,8 (1,6)
138	Монголия	1,7 (1,4)
139	Молдавия	1,3 (1,6)


Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг улс орнуудын авто замжилтыг үнэлэх судалгаагаар 2011 онд манай улс 139 орноос 138 дугаар байранд үнэлэгджээ.

Эх сурвалж: (Дэлхийн эдийн засгийн форумын судалгаа)

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн Зээлийн гэрээг 2005 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр байгуулж, зам барилгын ажлыг 2008 онд дуусгахаар төлөвлөсөн боловч 2012 оны байдлаар буюу төлөвлөгөөт хугацаа 6 жилээр хэтэрсэн байхад 5 багц замын ажлаас 1 багцын гүйцэтгэл огт хэрэгжээгүй 2 багцын ажил дутуу хэрэгжилттэй байна.

**Засгийн газрын тогтоолоор батлагдсан гадаадаас авах ажиллах хүчний 37.2-69.6 хувь орж ирсэн байна.**

2.4 “Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоол батлагдсаны дараа журмын дагуу 31 хоногийн дотор гадаадаас ажиллах хүч оруулж ирдэг байна. Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөлд 2007-2012 онд гадаадаас ажиллах хүч оруулж ирсэн хугацаа болон дарааллыг харуулбал:



2.5 Гадаадын зээл тусламжаар хэрэгжих авто замын төслийн гүйцэтгэгч болон ТХН 2008-2011 онуудад, гадаадаас оруулах ажиллах хүчний саналаа өмнөх оны 12 сард багтаан ЗТБХБЯ-нд хүргүүлснийг хянаж нэгтгээд 7-55 хоногийн дотор НХХЯ-нд хүргэсэн байна.



2.6 НХХЯ-наас саналыг хянаж нэгтгээд 40-96 хоногийн дотор төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулж “Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” тогтоол батлагдсан байна.

2.7 Гүйцэтгэгч компани ажиллах хүч оруулах хүсэлтээ Засгийн газрын тогтоол гарснаас хойш 15-35 хоногийн дараа ХХҮГ-т хүргүүлснийг, тус газар журмын дагуу 5-14 хоногт шийдвэрлэж, ГИХАЭГ-т шилжүүлснээр 3-14 хоногт визийн зөвшөөрөл гарсан байна.

2.8 2009 онд гадаадаас ажиллах хүчин оруулах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зөвшөөрөл авахаар Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн гүйцэтгэгч Чайна Жео-Инженеринг ХХК, Шенгли инженеринг констракшн ХХК-ийн саналыг 2009 оны 2 дугаар сарын 17-нд, Ханшин инженеринг энд констракшн ХХК-ийн саналыг 3 дугаар сарын 11-нд ЗТБХБЯ-наас НХХЯ-нд хүргэсэн байна.

2.9 Дээрх саналд тусгагдсан БНСУ-ын “Ханшин инженеринг энд констракшн” ХХК 703, БНХАУ-ын “Чайна Жео-Инженеринг” ХХК 780, “Шенгли инженеринг констракшн” ХХК 292, нийт 1775 гадаад ажилчин оруулж ажиллуулахаар ЗТБХБЯ-наас НХХЯ-нд хүргүүлсэн саналыг хянаж 1050 болгон Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 102 дугаар тогтоолоор баталжээ.

2.10 Энэ тогтоолд хамрагдаагүй үлдсэн БНХАУ-ын “Чайна Жео-Инженеринг” ХХК-ийн 330, Шенгли инженеринг констракшн ХХК-ийн 92 гадаад ажилчдыг дахин оруулж ирэх санал хүргүүлснийг 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын 228 дугаар тогтоолоор баталсан ба замын ажил хийгдэх хугацаа оройтсон шалтгаанаар гүйцэтгэгч компани гадаад ажилчдаа оруулж ирээгүйгээс төлөвлөсөн ажил дутуу хийгдсэн байна.

2.11 2007, 2009, 2010 оны 4-5 дугаар саруудад гадаадаас ажиллах хүч оруулж ирэх Засгийн газрын тогтоол гарч байсан нь Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төслийн замын ажил төлөвлөгөөнөөс хоцроход нөлөөлжээ.

2.12 Засгийн газрын тогтоолоор батлагдсан гадаад ажилчдын 37.2-69.6 хувийг оруулж ирэн хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авч байсан нь замын ажлын гүйцэтгэл удаашрахад хүргэсэн нэг шалтгаан болжээ.

*Дутуу оруулж ирсэн ажилчдын тоог хүснэгтээр үзүүлбэл:*

№	Гүйцэтгэгч компани	Гэрээ байгуулсан огноо	2007	2008	2009	2010	2011	2012-06-25
			ЗГ-ын баталсан квотоос дутуу оруулж ирсэн зөрүү					
Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл								
1	Чайна жео-инженеринг	2006-12-28	98	262	675	284	191	18
2	БНСУ Ханшин инженеринг Констракшн	2007-04-04	82	253	373	-	-	-
3	Шингли инженеринг энд констракшн	2008-01-24	-	22	105	348	270	-
4	Жянши уотер энд хайдропауэр констракшн	2012-02-15	-	-	-	-	-	224
5	Халла инженеринг энд констракшн	2012-02-15	-	-	-	-	-	163
Б	ДҮН		220	537	1153	632	461	405

В	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл							
6	Чайна жиансү жианда констракшн	2010-12-22	-	-	-	-	154	130
7	Чайна гезоуба групп констракшн	2010-08-04	-	-	-	-	325	136
	ДҮН						479	266
	НИЙТ ДҮН		220	537	1153	632	940	671

Төсөл хэрэгжих хугацаанд гүйцэтгэгч компаниуд гадаадаас оруулж ирэх ажиллах хүчийг жил бүр ЗГ-ын тогтоолд зааснаас дутуу оруулж ирж байжээ. “Чайна Жео инженеринг” ХХК 2010 онд оруулж ирсэн 216 ажилчдаасаа 27-г нь “Жилин мандал” ХХК-д шилжүүлэн ажиллуулж байсан нь Засгийн Газрын тогтоолыг зөрчиж төлөвлөгөөт ажил удаашрахад нөлөөлжээ.

### **Зам барилгын ажилд стандарт, норм дүрмийг мөрдөж ажиллахгүй байна**

2.13 Орчин үеийн дэвшилт технологийг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах, гадаадаас нийлүүлж байгаа материал, замын хучилтад ашиглах битумыг Монгол орны эрс тэс уур амьсгалд тохирч байгаа эсэх талаар судалгаа шинжилгээний ажлууд хийгдсээр байна. Тухайлбал:

*Монгол орны эрс тэс уур амьсгалд тохирох битумын судалгааг Канад улсын Калгарын их сургуулийн туршилт судалгааны төвд хийлгэсэн байна.*

Гэвч энэхүү туршилтаар батлагдаж стандартын шаардлага хангасан битумыг төдийлөн ашиглахгүй байгаагаас хучилтын чанар муудахад нөлөөлж байна.

*Тухайлбал: “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл”-ийн В1 БАГЦ-ын 131.2 км замын хучилт ашиглалтад ороогүй байхдаа эвдэрсэн байна.*

2.14 Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа авто замын төслүүд олон улсын зээлийн гэрээгээр зохицуулагдаж, зөвлөх багийн хяналтад баригдаж байгаа хэдий ч чанарын хувьд шаардлага хангахгүй байна.

2.15 Энэ тохиолдолд итгэмжлэгдсэн лабораторийн журмыг мөрдөн ажиллах, туршилтаар баталгаажсан материалыг зам барих ажилд хэрэглэж байгаа эсэхэд лабораторийн хөндлөнгийн хяналт тавьж ажиллах нь оновчтой юм.



*В1 багцын 131,2 км замын хучилт эвдэрсэн байдал*

2.16 Мөн гэрээний бүрэлдэхүүн хэсэгт орсон ажлуудын хэрэгжилт хангалтгүй буюу огт хийгдэхгүй байна. Тухайлбал:

- ❖ Төслийн зам дагуу амралтын цогцолбор газар байгуулах
- ❖ Замыг цаснаас хамгаалах зорилгоор мод тарих
- ❖ Зам дээр авто машины даацыг хэмжих пүүг байрлуулах
- ❖ Хил дамнансан авто тээврийг хялбаршуулах төлөвлөгөө
- ❖ Зам баригдаж буй орон нутгийг хөгжүүлэх

зэрэг ажлууд одоогоор судалгаа хийх, тендерийн материал боловсруулахаас хэтрээгүй байна.

### **Зөвлөх багийн ажил хангалтгүй нь замын чанар муудахад нөлөөлсөн байна**

2.17 Олон улсад мөрдөж байгаа FIDIC-ийн гэрээнд төсөлд оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тусгасан байдаг.

2.18 Гэрээнд тусгаснаар олон улсад дагаж мөрдөгддөг техникийн даалгавар, нөхцөл, нийтлэг журам, дүрмийн дагуу төслийн үйл ажиллагаа явагддаг байна.

2.19 Гүйцэтгэгч компани зам барилгын ажлын стандарт, нормыг баримтлахгүй, технологийн горимыг зөрчиж, шаардлага хангахгүй материалыг зам барихад ашиглаж байхад төслийн ажлын явцад зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан компани ажлыг нь үргэлжлүүлэн хийлгэсэн байна. Тухайлбал:

*“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдаж буй В1 багцын 131,2 км гүйцэтгэгчээр “Чайна жео инженеринг” ХХК ажиллаж байна. Тус замд АЗГ-ын техник ашиглалтын түвшин тогтоох баг ажиллаж шаардлага хангасан дүгнэлт гаргасан боловч ашиглалтад орохоос өмнө эвдэрсэн байна. Энэ нь барилгын ажлын явцад зөвлөх багийн хяналт хангалтгүй, зам барилгын ажлын стандарт, техникийн шаардлага зөрчигдөж байгааг харуулж байна.*

2.20 Авто замын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй зөвлөх багууд гэрээнд зааснаар дараах бүрэлдэхүүнээр ажиллах ёстой боловч төслийн багцын ажлууд хэрэгжихгүй байгаагаас бүрэн хэмжээгээр ажиллаж чадахгүй байна. *Тухайлбал:*

№	Төслүүдийн нэр	Зөвлөх компанийн нэр	ИТА	Зөвлөх багийн			
				Гадаад мэргэж илтэн	Дотоод мэргэж илтэн	Туслах ИТА	
1	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл	Ай Си Ти	Гэрээгээр	9	38	11	
			Ажиллаж байгаа	1	3	3	
2	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх	Эн Би СиСи	Гэрээгээр	4	15	-	
			Ажиллаж байгаа	4	10	-	
3	Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор авто зам барих	МСРС gr	Гэрээгээр	1	8	-	
			Ажиллаж байгаа	-	8	-	
4	Уньт-Тариалан чиглэлийн авто замын төсөл	Абудулазиз ол фулайж Сүүсанг Ти Ай Би	Гэрээгээр	5	13	-	
			Ажиллаж байгаа	2	2	-	
5	УБ хотын хүнсний хангамжийг сайжруулах тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл	Ай Си Ти	Гэрээгээр	6	5	7	
			Ажиллаж байгаа	6	5	10	
<b>Дутуу ажиллаж байгаа ИТА</b>				<b>Гадаад мэргэжилтэн</b>	<b>12</b>	<b>-</b>	<b>-</b>
				<b>Дотоод мэргэжилтэн</b>	<b>-</b>	<b>51</b>	<b>-</b>
				<b>Туслах ИТА</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>8</b>

Төсөл хэрэгжүүлэх гэрээт хугацаанд зөвлөх багийн инженер техникийн ажилтнуудын цалингийн зардалд 1.3 сая ам долларыг зарцуулсан байна.

2.21 Ай Си Ти Сайн консалтинг зөвлөх компанийн хяналт тавин ажиллаж байгаа “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдаж байгаа зарим багц ажлууд чанарын хувьд хангалтгүй, хэрэгжилт удаан байгаа боловч тус компани “Улаанбаатар хотын хүнсний хангамжийг сайжруулах тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-д давхар хяналт тавин ажиллаж байна.

2.22 Үүнээс харахад зарим зөвлөх компаниуд инженер техникийн ажилчдын нөөц хүчийг олон объектод хуваах, нэрийг давхардуулах зэрэг шалтгаанаар зам барилгын ажилд зөвлөх багийн хяналтыг сулруулж байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, шинжилгээний дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ❖ Авто замын салбарын хөрөнгө оруулалт өсөж байгаач зам барилгын ажлын чанар хангалтгүй, хугацаандаа хэрэгжихгүй байна.  
Энэ нь худалдан авах ажиллагаа удааширсан, зам барилгын ажилд стандартын шаардлага хангасан материал ашиглаж, чанартай гүйцэтгэж чадахгүй, хяналт сул байгаатай холбоотой байна.
- ❖ Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохион байгуулалт хангалтгүй, шат дамжлага их байгаа нь төслийн хэрэгжилтийг хурдасгах, ажлыг чанаржуулах хөшүүрэг болж чадахгүй байна.
- ❖ Олон улсын зээлийн гэрээнд заасан зарим тусгай нөхцөлөөс шалтгаалж үндэсний компаниуд ажил гүйцэтгэх боломжоор хангагдахгүй, тендерт ихэвчлэн гадаадын компаниуд шалгарч байна.
- ❖ Зам барилгын үйлдвэрлэл дээр ажиллах боловсон хүчний нөөцийг эх орондоо бэлтгэх ажлын зохион байгуулалт муу, гадаадын иргэдийг Монгол Улсад оруулж ирэх явдал саарахгүй, манай улсын ажилгүй иргэдийн тоог цөөрүүлэхэд дорвитой нөлөөлж чадахгүй байна.
- ❖ Авто замын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй зөвлөх багууд гэрээнд заасан бүрэлдэхүүнээр ажиллаагүй, инженер техникийн ажилчдын нөөц хүчийг олон объектод хуваах, нэрийг давхардуулах зэрэг шалтгаанаар зам барилгын ажлын зөвлөх багийн хяналтыг сулруулснаас замууд чанаргүй баригдаж байна.
- ❖ Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт хангалтгүйгээс санхүүгийн нөөц үргүй зарцуулагдаж байна.

*Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:*

**Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт**

- ❖ Авто замын салбарт хэрэгжүүлэх төслийн зээлийн гэрээг байгуулахдаа салбар хариуцсан байгууллагууд, мэргэжлийн хүмүүсийн саналыг авах, хэрэгжих үндэслэл муутай зээлийн гэрээг байгуулахгүй байх,
- ❖ Олон улсын болон хандивлагч улс орнуудаас авах зээл, тусламжийн гэрээний нөхцөлд төслийн гүйцэтгэгчээр үндэсний компаниуд ажиллах боломжтой зүйл заалтуудыг тусгах арга хэмжээ авах

**Хөдөлмөрийн сайд Я. Санжмятавт**

- ❖ Гадаадаас ажиллах хүч оруулж ирэх тухай Засгийн газрын шийдвэрийг тухайн оны 2 дугаар сарын 20-ны дотор гаргаж байхад анхаарч ажиллах

**Зам, тээврийн сайд А. Гансүхэд**

- ❖ ТУХ болон бусад холбогдох байгууллага, нэгжүүдийг хууль журмын дагуу ажиллуулах
- ❖ Гадаадын зээл тусламжаар баригдаж байгаа авто замууд хугацаандаа ашиглалтад орж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж, зам барилгын ажлын явцыг түргэтгэх, гэрээний хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч, холбогдох арга хэмжээ авах

**Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Р.Ононд**

- ❖ Хандивлагч орнуудын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, баригдаж байгаа замын чанарт анхаарч, зөвлөх багийн үйлчилгээг сайжруулах, стандарт норм дүрэм, итгэмжлэгдсэн лабораторийн журмыг барьж ажиллах
- ❖ Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, барилгын ажлын хугацааг төлөвлөгөөнөөс хоцроож байгаа зөвлөх болон гүйцэтгэгч байгууллагуудад зээлийн гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох
- ❖ Авто замын салбарт ажиллаж байгаа хүмүүсийг мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлэх санал боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

**Боловсрол, шинжлэх ухааны сайд Л. Гантөмөрт**

- ❖ Авто замын салбарт инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэхэд анхаарч энэ чиглэлээр их дээд сургууль болон МСҮТ төгсөгчдийн тоог нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авах

# Холбогдох байгууллагын санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: 7011-2333, Факс: (976-11) 31-23-15,  
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2012.09.10 № 1/138  
танай 2012.09.31 -ны № 3/922 -г

Танай ирүүлсэн "Авто замын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн бодлого хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн дүгнэлттэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар 1

1.28.Төслийн захирал нь төслийн зохицуулагчтай гэрээ байгуулдаг тул энэ дүгнэлтийг хасах;

Тайлбар 2

2.14. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн ажил гүйцэтгэх гэрээ нь олон улсад мөрдөгдөж байгаа FIDIC-ийн гэрээгээр зохицуулагдаж байгаа ба энд туршилт шинжилгээг хэн гүйцэтгэх, хэн баталгаажуулах нь тодорхой заагддаг бөгөөд төслүүдэд гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна гэж үзэж байгаа тул дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй байна;

Тайлбар 3

2.15."Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн 133.5 км замын хучилтын асфальтбетон хольцын орц, нормыг тогтоож баталгаажуулсан лабораторийн туршилт шинжилгээний баталгаажсан актыг өмнө нь хүргүүлсэн болно;

Тайлбар 4

2.16.Дэлхийн эдийн засгийн формын судалгаа нь замын чанарт биш, хүн амд ногдох замжилтын үзүүлэлтэд өгдөг үнэлгээ гэдгийг дахин дурьдахыг хүсч байна. Энэ дүгнэлтийг хасах; (Мөн дүгнэлт хэсгийг харна уу)

Тайлбар 5

2.20., 2.24. Тодорхой баримтад тулгуурлан дүгнэлтийг бичих.

Тайлбар 6

Мөн "Гадаадын зээл, тусламжийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх зохистой бүтэц бий болоогүй байна" гэсэн толгой гарчигтай хэсэгт 1.36-1.39 хэсгийг хамруулан нэгтгэж дүгнэлтийг гаргах нь зүйтэй ба 1.40 хэсэг нь бүтцийн өөрчлөлтийн туршилттай огт холбогдолгүй ба туршилтыг 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн болно. Дээр дурьдсан 1.40 хэсгийг худалдан авах үйл ажиллагаанд 2 жил зарцуулжээ хэсэгт хамруулан нэгтгэх нь зүйтэй байна.

Дээр дурьдсан саналуудыг тайлангийн төсөлд тусгана уу.



А.ТАНСУХ

08 000207

## Зам, тээврийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар

Тайлбар 1	Саналыг хүлээн авч өгүүлбэрийг тайлангаас хасав.
Тайлбар 2	Тайланд найруулгын өөрчлөлт оруулав. Тухайн зам нь гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр олон улсын гэрээний дагуу хэрэгжиж байгаа хэдий ч чанарын хувьд шаардлага хангахгүй бол итгэмжлэгдсэн лабораториор хөндлөнгийн хяналт хийлгэх тухай АЗГ-ын даргын 2010 оны 12 дугаарын сарын 31-ний өдрийн 251 дүгээр тушаалын хавсралтаар баталсан журамд заасан байна.
Тайлбар 3	Саналыг хүлээн авч өгүүлбэрийг тайлангаас хасав.
Тайлбар 4	Саналыг хүлээн авч тайланд найруулгын өөрчлөлт оруулав.
Тайлбар 5	Б1 багц 131,2 км замд техник ашиглалтын түвшин тогтоох баг ажиллаж хэмжилт судалгаа хийсэн болон лабораторийн шинжилгээ туршилтын дүгнэлтийг үндэслэн бичсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 6	1.36-1.40 дугаарт орсон өгүүлбэрүүдэд Сангийн сайд, ЗТБХБС-ын 2011 оны хамтарсан 237/187, Сангийн сайдын 2007 оны 120 дугаар тушаалаар батлагдсан ТХН-ийн бүтцийг схемээр харуулсан болно. Энэ нь төсөл хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах зохистой бүтэц бий болоогүй байгаа талаарх гарчигтай уялдаж буй учир өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.





МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2012 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 111


Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Авто замын салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн бодлого, хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр нарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг холбогдох сайд нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД